

БУЛГАН АЙМАГ ДАХЬ БУЛГАН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД
АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.08.25

Булган сум

ИНЕГ-ын даргын баталсан 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Булган аймаг дахь Булган нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 14/21 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор А.Мөнх-Эрдэнэ, О.Сэндэр, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Булган аймаг дахь Булган нисэх буудлын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Дотоод аудитын албанаас хийгдсэн хяналт, шалгалтаар 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацааны үйл ажиллагаа, захиргаа, санхүүг шалгахад цалин хөдөлмөрийн хөлсний тооцоолол, бодолт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд зөрчил илрээгүй буюу хангалттай байна.

Нисэх буудлын 2020 он, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ИНҮТ-ийн даргаар батлуулаагүй, хагас жил болон жилийн эцсийн байдлаар ИНҮТ-өөс биелэлтийг үнэлээгүй.

Тушаал, албан бичгүүд утга найруулга, үг үсгийн алдаатай, огноо, дугаарыг зассан, эрх бүхий албан тушаалтны баталсан тушаалд ажилтнуудаар гарын үсэг зуруулсан нь “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг зөрчсөн.

Тус нисэх буудал нь дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрүүдийг хяналтад авч бүртгэлжүүлээгүй, хяналтын карт хөтөлдөггүй, заалт тус бүрээр хяналтад аваагүй байна.

Үндэсний архивын газрын даргын 2007 оны “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”, ИНЕГ-ын даргын 2016 оны А/415 дугаар тушаалаар баталсан “Архивын ажлыг эрхлэн хөтлөх заавар”-ын мөрдөн ажиллаагүй, мэдлэг хангалтгүй байна.

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын заалтыг зөрчсөн, захиргааны мэргэжилтэн цаг бүртгэлийг үндэслэн цагийн тооцоо гаргаагүй, цаг бүртгэлийн дэвтэрт тавих хяналт хангалтгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй, нэхэмжлэх байхгүй, анхан шатны баримтын эх хувийг хавсаргаагүй, албан томилолтын тооцоо хангалтгүй байна.

Нисэх буудалд ашиглагдаж буй технологийн болон сумлагч автомашинуудын жолоочийн замын хуудас тооцоо хөтлөөгүй, автомашины гүйлтийг спидометрийн заалттай тулгалгүйгээр

шатахууны тооцоог хийсэн, автомашинуудын хувийн хэргийн бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.

Дизель генераторуудын мотоцагийн заалттай уялдуулж шатахууны тооцоог хийгээгүй, нөхөн хангалтын ажилтан ажиллуулахдаа актаар ажил хүлээлцэхгүй байна.

Тус нисэх буудлын ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажилтнууд нэг дэх шатны хяналтыг 2021 оны 03 дугаар сар хүртэл өдөр тутам явуулаагүй.

Нисэх буудлын барилгын 3 дугаар давхарт гарах шат нь огцом, бариул хамгаалалтаар тоноглогдоогүй, мөн нисэх буудлын галын дохиоллууд нь бүрэн ажиллахгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай.

Нисэх буудлын дотоод аудитын орон тооны бус багийн 2020 он, 2021 оны үйл ажиллагаа, баримтыг шалгахад үзлэг шалгалт гүйцэтгэхдээ удирдамж батлуулаагүй, хяналт шалгалтын ажлаа тайлагнаагүй, нэгтгэн дүгнээгүй, холбогдох баримтыг нэгтгэж архивын нэгж үүсгээгүй байна.

ТС-1 шатахууны тооллогод зөрчил илрээгүй боловч ИНЕГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.3.2-т заасны дагуу шатахууны сав (ТС-1)-ыг зориулалтын лацаар лацдаагүй, бүртгэл хөтлөөгүй байна.

ИНЕГ-ын Дотоод аудитын албанаас 2020 оны 11 дүгээр сард 20/31 дугаартай удирдамжийн дагуу хийсэн Дотоод аудит хяналт, шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 73.3 хувьтай байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар тус албанд 18 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА